



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 9 сарын 27 өдөр

Дугаар 168

Улаанбаатар хот

Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралтад нэр дурдсан 9 үнэт цаасны компанийн үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. Компанийн оноосон нэрээс “ҮЦК” тэмдэглэгээг хасуулж, үйл ажиллагааны чиглэлээ өөрчлөхийг хавсралтад нэр дурдсан 9 компанийн удирдлага, эрх бүхий албан тушаалтанд үүрэг болгосугай.

3. Нэр бүхий 9 компанийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч, Санхүүгийн зохицуулах хорооны бүртгэлд холбогдох өөрчлөлт хийж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийт болон харьяалагдах татварын алба, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт ажлын 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны 2017 оны
9 дүгээр сарын 17-ны өдрийн 168 дугаар
тогтоолын хавсралт



№	Компанийн оноосон нэр	Үйл ажиллагааны чиглэл
1	"Бага хээр ҮЦК" ХХК	Брокер, дилер
2	"Бумбат шигтгээ ҮЦК" ХХК	Брокер, дилер
3	"Превалент ҮЦК" ХХК	Брокер, дилер, андеррайтер
4	"Сэлэнгэ түмэн ҮЦК" ХХК	Брокер, дилер
5	"Финанс линк групп ҮЦК" ХХК	Брокер, дилер
6	"Говийн ноён нуруу ҮЦК" ХХК	Брокер, дилер
7	"Би Би Эс Эс ҮЦК" ХХК	Брокер, дилер
8	"Зюс капитал ҮЦК" ХХК	Брокер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх
9	"Эм Даблю Ти Эс ҮЦК" ХХК	Брокер, дилер